

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 65.020.40

Гүзээлзгэний суулгац. Техникийн ерөнхий шаардлага	MNS 6374 : 2013
Strawberry seedlings. General technical requirements	

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2013 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 10 дугаар тогтоолоор батлав

Энэ стандартыг 2013 оны 3 дугаар сар 29-ний өдрөөс эхлэнэ мөрдөнө.

1. ХАМРАХ БА ХЭРЭГЛЭХ ХҮРЭЭ

1.1 Энэхүү стандарт нь гүзээлзгэний суулгац үржүүлэх, шалгаж хүлээн авах, савлах, борлуулах, импортлох, хадгалах, тээвэрлэх үйл ажиллагаанд хамаарна.

1.2 Энэ стандартыг баталгаажсан технологийн дагуу гүзээлзгэний суулгацыг үржүүлдэг мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэд болон хяналт шалгалтын эрх бүхий байгууллагууд, худалдан авагчид хэрэглэнэ.

1.3 Энэхүү стандарт нь гүзээлзгэний үндэсний шижим, үрээр үржүүлсэн суулгацад хамаарахгүй.

2. НОРМАТИВ ИШЛЭЛ

Энэхүү стандартад дараах баримт бичгийг иш татсан бөгөөд эдгээр стандартад өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны материалаас иш татаж хэрэглэнэ.

- MNS 6250:2011, Чацарганы суулгац, техникийн шаардлага,
- MNS 6251:2011, Үхэр нүдний суулгац, техникийн шаардлага.
- ГОСТ Р 53135-2008, Посадочный материал плодовых, ягодных, субтропических, орехоплодных, цитрусовых культур и чая. Технические условия
- MNS SAC-1:2007, “Савласан бүтээгдэхүүний шошгололтонд тавигдах ерөнхий шаардлага”

3. НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ

3.1 Гүзээлзгэний суулгац

Үржүүлгийн эх цэцэрлэгээс ургал эрхтнээр нь үржүүлэн гаргаж авсан, жимст цэцэрлэг байгуулахад зориулагдсан нэг настай суулгац, гүзээлзгэний суулгац нь эх ургамлын зөвхөн ургал эрхтнээр үржүүлэгддэг тул тухайн сортын онцлог чанар, шинж тэмдэгийг бүрэн хадгалсан байдаг.

3.2 Жимст цэцэрлэг

Жимс хурааж авах зориулалттай цэцэрлэг,

3.3 Үржүүлгийн эх цэцэрлэг

Үржүүлэгт зориулан мөчир авахаар шигүү тариалсан цэцэрлэг,

3.4 Ургал эрхтнээр үржүүлсэн суулгац

MNS 6374 : 2013

Сахал болон ногоон мөчир, нахиагаар үржүүлсэн суулгац,

3.5 Нэг настай суулгац

Ургал эрхтнээс авч үндэслүүлсэн суулгац,

3.6 Бойжуулгын талбай

Ногоон мөчир болон сахлаар үндэслүүлсэн тарьцыг суулгац болтол нь ургуулах тусгайлан бэлтгэсэн талбай,

3.7 Механик гэмтэл

Мөчир, салаа иш, үндэс, холтсонд үүссэн шалбархай, хугарал, бяцрал, халцрал,

3.8 Амь чийг

Мөчир салаа иш, үндэс хорчийж, чийг алдагдлын шинж тэмдэг илрээгүй байдал,

3.9 Суулгацын өндөр:

Үндэсний хүзүүвчээс орой хүртэлх хэмжээ,

3.10 Хоовон

Суулгац үржүүлэх зорилгоор ашигладаг хуванцар, хатуу цаасан зэрэг янз бүрийн материалаар хийсэн сав,

3.11 Навчны хар толбожилт

Мөөгөнцөрөөр үүсдэг өвчин.

/Өвчний шинж тэмдэг навч, жимс, зарим тохиолдолд үрийн гадаргууд хар өнгийн толбо үүсэх байдлаар илэрдэг./

3.12 Гуалих

Sphaerotheca maculans (Wallr.) Magnus - мөөгөнцрийн гаралтай өвчин.

/Өвчилсөн навчны доод гадаргуу улаан ягаавтар өнгөтэй болж, ирмэг хэсгээрээ дээш эргэж хуйлрах байдал илэрдэг./

3.13 Цагаан толбожилт

Mycosphaerella Fragariae (Tul.) Lindan - мөөгөнцөрөөр үүсдэг өвчин.

/Өвчлөлтийн эхний шатанд өвчний шинж тэмдэг навчны дээд талын гадаргууд ягаандуу өнгийн, дугуй хэлбэртэй толбо үүсэх байдлаар илэрдэг. Яваандаа толбоны голын хэсгийн өнгө цайрч, хүрээ нь ягаан хэвээрээ үлддэг./

3.14 Үндэсний хар илжрэл

Хэд хэдэн зүйлийн мөөгөнцөрөөр үүсгэгддэг өвчин.

/Өвчилсөн үндэс харлаж илжрэх бөгөөд суулгац давжаа болно./

3.15 Хачиг

Tetranychus urticae - Навчны шүүсийг сорж хооллон хөнөөл учруулдаг. Гэмтсэн навч цоохордох, үрчийх, хүрээнтэй шинж илэрдэг.

4. АНГИЛАЛ

4.1 Үржүүлж гарган авсан аргаас нь хамааруулж гүзээлзгэний суулгацыг

- ногоон мөчрийн
- сахлын
- үрийн гэж тус тус ангилна

4.2 Ногоон мөчир болон сахлаар үржүүлж гарган авсан гүзээлзгэний 1 настай суулгацыг үржүүлгийн эх болон жимст цэцэрлэг байгуулах зориулалтаар тариална.

4.3 Гүзээлзгэний үрээр үржүүлж гарган авсан суулгацыг шинэ сорт гаргахад ашиглана.

5. ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

5.1 Гүзээлзгэний суулгацыг баталсан технологийн зааврыг баримтлан үржүүлнэ.

5.2 Гүзээлзгэний үржүүлгийн эх цэцэрлэгт сортын хянан баталгаа хийлгэсэн байна.

5.3 Гүзээлзгэний суулгац нь сортын шинж чанараа бүрэн хадгалсан, бусад сортын хольцгүй байна.

5.4 Гүзээлзгэний үржүүлгийн эх болон жимст цэцэрлэг байгуулахад ногоон болон сахлаар үржүүлсэн нэг настай I-ээс II-р зэргийн суулгацыг тариална.

5.5 Гүзээлзгэний суулгацын гадаад шинж тэмдэгийн үзүүлэлтүүд дараах хүснэгтэд заасан шаардлагыг хангасан байвал зохино.

Гүзээлзгэний суулгацын чанарын болон гадаад шинж тэмдэгийн үзүүлэлтүүд

д/д	Үзүүлэлт	Суулгацын шинж тэмдэг	Зэрэг	
			I	II
Үндэсний систем				
1	Үндэсний урт	см-ээс багагүй, сахлаг үндэстэй	40	20
2	Олон наст үндэслэг ишний тоо	ширхэг	5	3
3	Өнгө	Бор хүрэн		
Газрын дээрх хэсэг				
1	Нэг наст ишний тоо	ш-ээс багагүй	8	5
2	голч	см-ээс багагүй	0,5	0,3
3	өнгө	Бор ногоон		
4	Гадаад байдал	Нэг наст ишний нахиа шалбарч гэмтээгүй, үндэс харлаагүй, амь чийгтэй		
5	Өвчин, хөнөөлт шавьжинд нэрвэгдсэн байдал	Илрэх ёсгүй		

ТАЙЛБАР 1: Гүзээлзгэний II-р зэргийн шаардлагад хүрэхгүй суулгацыг бойжуулгын талбайд дахин тарина.

ТАЙЛБАР 2: Хадгалалт, тээвэрлэлтийн үед гүзээлзгэний суулгацын нахиа нь 5%-иас хэтрэхгүй механик гэмтэлтэй байхыг зөвшөөрнө.

6. ДЭЭЖ АВАХ

6.1 Суулгацын стандартын дээрх хүснэгтэд заасан чанарыг баримтлан нийт суулгацын 10-аас доошгүй хувийг шалгаж хүлээн авна.

MNS 6374 : 2013

6.2 Зооринд хадгалсан хоовон болон үртэс бүхий хайрцагтай суулгац тутмаас 10%-иас доошгүй хувьд дээж авч шалгана.

7. ШАЛГАЖ ХҮЛЭЭЖ АВАХ

7.1 Гүзээлзгэний суулгацыг хүлэмжинд тарихын өмнө буюу хавар 3 сарын эхний арав хоногт, ил талбайд 5-р сарын эхний арав хоногт багтаан шалгана.

7.2 Суулгацын өндрийг шугам, голчийг штангенциркулиар хэмжинэ.

7.3 Суулгацын өвчин, хортон шавьжинд нэрвэгдсэн байдлыг MNS 2783:1979 “Ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүн. Мөөгөнцөрийн өвчнийг илрүүлэх арга”, MNS 2784:2007 “Ургамал, ургамлын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн. Бактерийн гаралтай өвчнийг илрүүлэх арга”, MNS 2782:1979 “Ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүн. Хортон шавьжийг илрүүлэх арга” стандартуудын дагуу тус тус тодорхойлно.

8. САВЛАЛТ, ШОШГОЛОЛТ

8.1 Суулгацын үндсийг боох: Үндсийг салхинаас хамгаалан нийлэг хальс, таар, шуудайн дээр чийглэсэн үртсийг жигд тараагаад битүү ороож боосон байна.

8.2 Хоовонтой суулгацыг 10-аас 15 ширхэгээр цаасан хайрцаганд хийж гадна талд шошго наана.

8.3 Савалсан суулгацыг тээвэрлэхэд зориулан үндсийг гадны нөлөөллөөс бүрэн хамгаалах нийлэг хальс, таар шуудайн дээр чийглэсэн үртсийг жигд тараагаад, суулгацын үндсийг шороон зуурмагт хутгаж үзүүрийг нэг тийш нь харуулж тавиад өөр хоорондоо үрж холхихгүйгээр модны үртэс эсвэл шороогоор хөдөлгөөнгүй болтол чигжсэний дараа битүүлэн ороож бооно.

8.4 Суулгацанд дараах мэдээлэл бүхий шошго, зааврыг дагалдуулна.

- Суулгац үйлдвэрлэгч байгууллага, аж ахуй нэгж, иргэний нэр, хаяг,
- Стандартын дугаар, тэмдэглэгээ,
- Сортын нэр,
- Суулгацын тоо, ширхэг,
- Хадгалах хугацаа, нөхцөл,
- Тарьж ургуулсан он,
- Тарьж суулгах, заавар,

9. ХАДГАЛАЛТ

9.1 Үржүүлгийн хүлэмжинд хоовонд бойжуулсан суулгацыг өвөлжүүлэхдээ цаасан хайрцаганд 10-аас 15 ширхэгээр хийж ариутгалын бодисоор шүршин өвөлжүүлнэ.

9.2 Ил талбайн үржүүлгийн газраас авсан суулгацыг өвөлжүүлэхдээ чийгтэй үртэстэй цаасан хайрцаганд хийж зооринд өвөлжүүлнэ.

9.3 Суулгац хадгалах зоорийг ариутгасан байх шаардлагатай бөгөөд хадгалалтын горимыг баримтлах хэрэгтэй.

10. ТЭЭВЭРЛЭЛТ

10.1 Савласан суулгацыг тээвэрлэхдээ тээврийн хэрэгслээр тэвш хашлага дотор доор нь 10-аас 15 см зузаан зөөлөвч дэвсэж босоо байдлаар эгнүүлэн тавьж ачих бөгөөд боодлын хоорондох зай завсарт чийгтэй үртэс юмуу шороогоор чигжиж дүүргэнэ. Хол тээвэрлэх тохиолдолд үндсийг тогтмол чийглэж хатахаас хамгаалах арга хэмжээ авах шаардлагатай.

10.2 Хайрцагласан суулгацыг нарны шууд тусгалаас хамгаалж сэрүүн нөхцөлд тээвэрлэнэ.

10.3 Хайрцагтай суулгацыг хэт хүнд зүйлээр дарж бяцлах, уут задарч үндэс ил гарахаас сэрэмжлэх, шатах дэлбэрэх, бохирдуулах бодистой хамт тээвэрлэхийг хориглоно.

10.4 Тээвэрлэлтийн нэг удаагийн үргэлжлэх хугацаа 4 хоногоос хэтрэхгүй байна.

ТӨГСӨВ.